



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/40

Ханх сум

Сумын Заан цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/257 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103, Ханх сум үүсгэн байгуулагдсаны 93 жилийн ойн баяр наадмын “Үндэсний бөх”-ийн барилдаанд түрүүлэн сумын заан цолны болзол хангасан тул (Б.Тайванбаяр)-т сумын заан цол олгосугай.

2.Цолны дагалдах мөнгийг баяр наадмын зардлын сангаас тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б. Баттүвшин)-д даалгасугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР

